

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 146 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

“146.5.Орон сууцны дэвсгэр болон орчны газартай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Газрын тухай хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт:

15.1.3.нийтийн орон сууцны дундын өмчийн эрх.

3 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг:

15.8.Орон сууцны байшингийн дэвсгэр болон орчны газрыг эзэмшихтэй холбоотой нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчийн эрхийг Газрын тухай хуулийн 44¹ дүгээр зүйлд зааснаар хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтын дугаарыг “7.2.3” гэж, мөн зүйлийн 7.2.5, 7.2.7, 7.2.8, 7.2.9, 7.2.10, 7.2.11 дэх заалтын дугаарыг “7.2.4”, “7.2.5”, “7.2.6”, “7.2.7”, “7.2.8”, “7.2.9” гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 15.7, 15.8 дахь

хэсгийн дугаарыг “15.5”, “15.6”, “15.7” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.6, 18.1.7 дахь заалтын дугаарыг “18.1.4”, “18.1.5” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтын “орон сууцны хэвийн ажиллагааг хангах зорилгоор сан байгуулах, зээл авах” гэснийг, мөн зүйлийн 7.2.8 дахь заалтын “ашиглалт” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3, 7.2.6 дахь заалт, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.4, 18.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуулийн 15¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь хэсэг нэмсүгэй:

“15^{1.8}. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулахгүй гэж сууц өмчлөгчдийн олонхи үзсэн бол нийтийн зориулалттай орон сууцны дэвсгэр болон орчны газрыг дундаа хамтран хязгаартайгаар эзэмшиж, ашиглах эрх дуусгавар болно.”

2 дугаар зүйл. Орон сууцны тухай хуулийн 15^{1.6} дахь хэсгийн “гарснаар тухайн орон сууцыг мэдээллийн нэгдсэн сангаас хасч ашиглах эрх дуусгавар болно” гэснийг “гарсан нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны дэвсгэр болон орчны газрыг дундаа хамтран хязгаартайгаар эзэмших эрх дуусгавар болох үндэслэл болохгүй” гэж, 15^{1.7} дахь хэсгийн “газар төрийн мэдэлд байна” гэснийг “газрыг сууц өмчлөгчид дундаа хамтран хязгаартайгаар эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Засаг дарга дэмжлэг үзүүлнэ” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийн “Барьж дуусаагүй үл хөдлөх эд” гэснийг “Орон сууцны зориулалтаар барьж байгаа барилгыг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхгүй ба бусад зориулалтаар барьж дуусаагүй үл хөдлөх” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/Нийтийн зориулалттай орон сууц, түүнтэй адилтгах орон сууцны өмчлөгчдийн нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчийн эрхээр баталгаажсан дундаа хамтран хязгаартайгаар эзэмшиж, ашиглах орон сууцны дэвсгэр болон орчны газрыг хэмжээ, хил заагийг хуульд заасны дагуу тогтоож, газрын кадастрын мэдээллийн сан болон эрхийн улсын бүртгэлд сууц өмчлөгчдийн үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй нэгтгэн бүртгэж дундын мэдээллийн санд оруулах.

2/Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахаас өмнө сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулахаар олгосон газар, иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, албан газрын эзэмшил, ашиглалтад буй нийтийн зориулалттай орон сууцны дэвсгэр болон орчны газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох ажлыг зохион байгуулах.

Гарын үсэг

